

Онис: 2021.7.1.

Хавсралт 1

## ПАЛЕОНТОЛОГИЙН ХАЙГУУЛ СУДАЛГААНЫ АЖЛЫН ДААЛГАВАР

### 1. Зорилго

Соёлын өвийг хамгаалах тухай хууль 27.8-д заасны дагуу ЭТТ ХК-ийн Тавантолгой ордын уурхайн тэлэлт, хөрсний овоолго хийгдэхээс урьтаж Монгол улсад мөрдөгдж байгаа хууль эрх зүйн хүрээнд палеонтологийн хайгуул судалгааг өгөгдсөн судалгааны талбайд хийж ажлын тайланг холбогдох Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Мэргэжлийн зөвлөлөөр баталгаажуулан захиалагчид хүлээлгэн өгнө.

Энэхүү ажил нь 2021 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн шалгуурын 0.762%-г эзэнтэй.

### 2. Нийлүүлэгчид тавигдах ерөнхий шаардлага

- Гүйцэтгэгч нь палеонтологи, археологийн эрдэм шинжилгээний хайгуул, малтлага хийх хуульд заасны дагуу холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас олгогдсон зөвшөөрөлтэй байна.

### 3. Хийгдэх ажлууд

- Судалгаанд хамрагдах талбайд палеонтологийн хайгуул судалгааны ажлыг хийж гүйцэтгэнэ.
- Судалгааны ажлыг Монгол улсын нутагт археологи, палеонтологийн хайгуул, малтлага, судалгаа хийх журмын дагуу гүйцэтгэнэ.
- Палеонтологийн судалгаагаар талбайн хэмжээнд илэрч болох палеонтологийн олдворуудын талаар тодорхойлолт бичих, өмнө гарч байсан олдворуудад дүгнэлт гаргах, талбайн гадаргууд хайгуул судалгаа хийх
- Судалгааны ажилтай холбоостой гарах зардлыг гүйцэтгэгч байгууллага хариуцна.

### 4. Ажлын үр дүн:

- Судалгааны тайланг 2 хувь хэвлэмэл үйлдэж, цахим (PDF болон .docx) хэлбэрээр хүлээлгэж өгнө.

### 5. Судалгаанд хамрагдах талбай:

- Бор толгой MV-011953A-12860 га  
Шар тээг MV-011955A-23803 га  
Бор тээг MV-011954A-8941 га